



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 313

Улаанбаатар хот

Жагсаалт, журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын иргэн өөрийн оронд эмчлэгдэх боломжгүй өвчин, эмгэгийн улмаас гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх "Өвчний жагсаалт"-ыг нэгдүгээр, "Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлаар санал гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн"-ийг хоёрдугаар, "Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлаар санал гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн ажиллах журам"-ыг гуравдугаар, "Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх иргэдэд эмнэлгийн дүгнэлт гаргах журам"-ыг дөрөвдүгээр, "Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх иргэдэд эмнэлгийн дүгнэлтийн маягт"-ыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй өвчин, эмгэгийн улмаас гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчилгээ хийлгэх иргэдэд эмч нарын зөвлөлгөөний дүгнэлт гаргах бүрэлдэхүүнийг хууль тогтоомжийн дагуу шинэчлэн чиг үүргийнхээ хүрээнд тушаалаар баталгаажуулан, удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаалыг 2013 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтуяа)-д үүрэг болгосугай.


5. Тушаал шинэчлэн батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын "Эмнэлгийн дүгнэлт гаргах журам, өвчний жагсаалт батлах тухай" 2011 оны 107, "Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай" 248 дугаар тушаалууд, 2012 оны 399 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтын "Гадаад эмчилгээний зөвлөл" гэсэн хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Н.УДВАЛ

Эрүүл мэндийн сайдын
2013 оны 08 дугаар сарын 29-ны
өдрийн 303 дүгээр тушаалын
1 дүгээр хавсралт



ГАДААД УЛСАД ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГААР
ЭМЧЛҮҮЛЭХ ӨВЧНИЙ ЖАГСААЛТ

№	Өвчний нэр		
	Монголоор	Оросоор	Англиар
A.	Мэдрэлийн мэс засал	Нейрохирургия	Neurosurgery
1	Гүрээний ба нурууны артерийн нарийсал, бөглөрлийн үеийн мэс засал	Хирургическое лечение при стенозе и окклюзии внутренних сонных и вертебральных артерий	Surgical intervention in the stenosis and occlusion of the internal carotid and vertebral arteries
2	Уртавтар тархины эмгэгийн мэс заслын эмчилгээ	Хирургическое лечение при болезни продолговатого мозга	Surgical intervention in oblongata
3	Паркинсоны өвчин, торсион дистони, эпилепси өвчний үеийн стереотакс мэс засал	Стереотаксическое хирургическое вмешательство при болезни Паркинсона, торсионной дистонии и эпилепсии	Stereotaxic surgical intervention in Parkinson disease, Torsion dystonia and Epilepsy
4	Тархины суурь хэсэг ба багана бүтцийн хавдрууд	Опухоли базальной и стволовой части головного мозга	Brain basal part and brainstem tumors
5	Тархины суурь ясны хавдар	Опухоль основной кости	Skull basilar bone tumor
6	Тархины 3 дугаар ховдлын хавдар	Опухоль третьего желудочка головного мозга	Brain third ventricle tumor
7	Дунд тархи ба багана бүтцийн байрлалтай мальформац	Мальформация локализованная в среднем мозге и в стволовой части	Midbrain and brainstem malformations
8	Тархи нугасны хавдрын гамма туяа эмчилгээ	Лечение опухолей головного и спинного мозга гамма облучением	Cyber knife, SBRT for brain and spinal cord tumor
Б.	Чих хамар хоолой	Отоларингология	Otorhinolaryngology
9	Сонсголын мэдрэлийн хавдар	Опухоль слухового нерва	Acoustic neuroma
10	Вегенерийн өвчний хүнд хэлбэр	Тяжелая форма болезни Веенера	Severe form of the Menieris diseases
11	Меньерийн өвчний хүнд хэлбэр	Тяжелая форма болезни Меньера	Severe form of the Vegeners disease
В.	Нүд судлал	Офтальмология	Ophtalmology
12	Нярайн ретинопати	Ретинопатия новорожденных	Infant Retinopaty

Г.	Зүрх, судасны мэс засал	Кардиоваскулярная хирургия	Cardiovascular surgery
13	Абляци эмчилгээ хийлгэх шаардлагатай зүрхний хэм алдагдал	Абляци при аритмии	Arrhythmia need to ablation
14	Зүрхний титэм судасны хүнд хэлбэрийн нарийсал	Тяжелая степень сужения коронарного сосуда сердца	Severe form of the coronary artery stenosis
15	Хүүхдийн хавсарсан хөх хүнд гажиг	Тяжелые синие врожденные аномалии сердечной перегородки	Severe form of Congenital malformations of cardiac septa
16	Зүрхний том судаснуудын гаж байрлал	Транспозиция больших сосудов сердца	Transposition of the heart great vessels
17	Гол судасны хүнд хэлбэрийн цүлхэнгүүд	Тяжелая форма аневризма аорты	Severe forms of the aortic aneurism
Д.	Хавдар	Онкология	Oncology
18	Толгой хүзүүний эрхтэний хавдрын өргөтгөсөн мэс заслын дараахь согогуудыг хиймэл эрхтнээр хаах	Реконструктивные протезирования после расширенных операций на органах головы и шеи	Prosthesis Reconstruction of functional deficit and anatomical defect after extended surgical treatment.
19	Шүлсний булчирхайн хорт хавдрын IMRT эмчилгээ	IMRT Радиотерапия рака слюнной железы	(IMRT) on Tumors of Salivary Glands
20	Цагаан мөгөөрсөн хоолойн хавдар	Рак трахеи	Cancer of the trachea
21	Улаан хоолой-цагаан мөгөөрсөн хоолойн фистул	Трахео-пищеводный свищ	Tracheoesophageal fistula
22	Туяа эмчилгээний дараах үтрээ-шулуун гэдэсний фистул	Прямокишечно-вагинальный свищ после радиотерапии	Rectovaginal fistul
23	Яс, зөөлөн эдийн хавдрын нөхөн сэргээх мэс засал - Мөч хадгалах боломжтой үеийн хорт хавдар - Бага аарцаг, цээжний хөндийн байрлалтай хорт хавдар	Реконструктивные операции мягких тканей и костей - Органосохраняющие операции на конечностях и гортани - Злокачественные опухоли плевральной полости и малого таза	Reconstruction Surgery of the Soft and Bone Tumors - Limb-sparing resection in the extremities and larynx - Malignant tumors of pelvis and thorax
Е.	Уушги судлал	Пульмонология	Pulmonologia
24	Уушгины төрмөл эмгэг	Врожденная патология легких	Congenital disorders of lungs

Ё	Гэмтэл согог судлал	Травматология ортопедия	и Traumatology and orthopedics
25	Түлэгдлийн улмаас үүссэн талбай ихтэй, том мөчид болон цээжний хэлбэр алдагдсан сорив	Послеожоговой стягивающий рубец	Deformities caused by burn scars
26	Дээд болон доод мөчдийн төрөлхийн хүнд хэлбэрийн дутуу хөгжил	Врожденная аномалия верхней и нижней конечности	Severe form of Congenital Amelia or hemimelia of limbs.
Ё	Ерөнхий мэс засал	Общая хирургия	General surgery
27	Ясны чөмөг шилжүүлэн суулгах мэх засал эмчилгээ	Трансплантация печени и костного мозга	Liver and bone cell transplantation
28	Зүрх шилжүүлэн суулгах мэс засал эмчилгээ	Трансплантация сердца	Cardiac transplantation
29	Элэгний вирусн идэвхижил өндөртэй өвчтөнд элэг бөөр, бөөр шилжүүлэн суулгах эмчилгээ	Трансплантация почки при высокой степени активности печеночного вируса	Kidney transplantation at the high level of virus activation
Ж	Эх барих эмэгтэйчүүд, үргүйдэл судлал	Акушерство, гинекология, бесплодия	Oobstetrics' and gynecology and infertility
30	Төрөлхийн адреногениталь хам шинж	Врожденный адреногенитальный синдром	Congenital Adrenal Hyperplasia
31	Эмэгтэйчүүдийн бэлэг эрхтний гаж хөгжлийн үе дэх нөхөн сэргээх хагалгаа	Пластическая операция Врожденной аномалии развития влагалища:	Complete Mayer – Rokitansky-Kustner-Hauser Syndrome: Vaginal re-constructive surgery
32	Өндгөвчний төрөлхийн дутуу хөгжлөөс үүдсэн үргүйдэл	Синдром истощений яичников	Subfertility due to premature ovarian failure
33	Эрэгтэйчүүдийн үрийн сувгийн эмгэгээс үүдсэн үргүйдэл	-Мужское бесплодие в связи с обструкцией семеноиспускательных каналов и с истощением гонад	-Male infertility due to obstructive azospermia and testicular failure

Эрүүл мэндийн сайдын
2013 оны ... дугаар сарын ...-ны
өдрийн ... дүгээр тушаалын
2 дугаар хавсралт



ГАДААД УЛСАД ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГААР ЭМЧЛҮҮЛЭХ
ИРГЭДЭД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АСУУДЛААР
САНАЛ ГАРГАХ ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Зөвлөлийн дарга: Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
- Дэд дарга: Эрүүл мэндийн яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
- Нарийн бичгийн дарга: Эрүүл мэндийн яамны эмнэлгийн тусламжийн хэлтсийн гадаад эмчилгээний чиг үүрэг хариуцсан мэргэжилтэн
- Гишүүд: Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга
 - Эрүүл мэндийн яамны эмнэлгийн тусламжийн хэлтсийн төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээний багцын бодлого, бүтэц уйл ажиллагааны стандартын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
 - Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга (зөвшилцсөнөөр)
 - Улсын нэгдүгээр төв эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал
 - Улсын хоёрдугаар төв эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал
 - Улсын гуравдугаар төв эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал
 - Хавдар судлалын үндэсний төвийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал
 - Гэмтэл согог судлалын үндэсний төвийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал
 - Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал



Эрүүл мэндийн сайдын
2013 оны 08 дугаар сарын 29-ны
өдрийн 313 дүгээр тушаалын
3 дугаар хавсралт

**ГАДААД УЛСАД ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГААР ЭМЧЛҮҮЛЭХ
ИРГЭДЭД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АСУУДЛААР
САНАЛ ГАРГАХ ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН
АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэ журмын зорилго нь Эрүүл мэндийн сайдын дэргэдэх гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлаар санал гаргах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн (цаашид “Зөвлөл” гэх) үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Зөвлөлийн ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хурал байна. Зөвлөлийн хурлыг гишүүдийн 75 хувиас дээш ирцийг бүрдүүлсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.
- 1.3. Зөвлөл нь “Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх өвчний жагсаалт”-д орсон өвчин, эмгэгтэй болохыг нь Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.10, 15.1.12-т заасан эмнэлгийн эмч нарын комиссын зөвлөгөөнөөс тогтоож, дүгнэлт гаргуулсан иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг зөвлөлдөн нийт гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 1.4. Зөвлөл нь 2 сар тутамд 1 удаа хуралдана. Шаардлагатай үед зөвлөлийн даргын шийдвэрээр хурлыг зарлан хуралдуулж болно. Хурлыг Зөвлөлийн дарга, түүний эзгүйд дэд дарга даргална.
- 1.5. Зөвлөл нь хуралдааны талаар хурлын тэмдэглэл хөтөлж, олонхийн саналаар шийдвэрлэсэн асуудлыг Эрүүл мэндийн сайдад танилцуулж шийдвэр гаргуулна. Тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлж, зөвлөлийн дарга, дэд дарга нар хянаж гарын үсэг зурж баталгаажуулна.

Хоёр. Зөвлөлийн эрх, үүрэг

- 2.1. Зөвлөлийн бүрэлдэхүүн нь хууль дээдлэх, шударга ёс, хариуцлага хүлээх зарчмын хүрээнд хуралдаанаар хэлэлцэгдэх иргэний санал хүсэлтэд тусгагдсан асуудлыг зөвлөлдөн хууль тогтоомжид нийцсэн нэгдсэн шийдвэр санал гаргуулахаар Эрүүл мэндийн сайдад дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй.
- 2.2. Зөвлөлийн бүрэлдэхүүн нь төрийн алба хаагчийн, эмчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж хүлээсэн үүрэгтээ үнэнч байж, нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхолын зөрчилд автахгүйгээр тухайн асуудлыг зөвлөлдөн шийдвэрлэнэ.
- 2.3. Зөвлөлийн хуралдаанаар “Журам батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3 дахь хэсэгт заасан материалыг өрхийн эмчийн тодорхойлолтын хамт бүрдүүлж, шаардлага хангасан иргэний асуудлыг хэлэлцэн санал гаргана.
- 2.4. Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх иргэний материалыг нарийн бичгийн дарга хурал зохион байгуулахаас 3 хоногийн өмнө гишүүдэд тарааж холбогдох материал тараасан талаар тусгай хуудсан дээр гарын үсэг зуруулна.

2.6. Зөвлөл нь гадаад эмчилгээний зардлын зарцуулалтын тайланг хагас жил тутам Эрүүл мэндийн сайдын зөвлөлд танилцуулна.

2.7. Гадаад улсад эмчлүүлэхээр санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн талаар нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, эрүүл мэндийн яамны цахим хуудсанд байрлуулна.

2.8. Зөвлөл нь гадаад эмчилгээний дэмжлэг хүссэн иргэдийн асуудлыг хүн нэг бүрээр нарийвчлан хэлэлцэж, баталгаажуулна. Баталгаажуулалт нь хурлын тэмдэглэл, шийдвэр байна.

2.9. "Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх өвчний жагсаалт"-д ороогүй өвчин, эмгэгтэй иргэн гадаад улсад эмчилгээний зардал хүссэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих хариуг уг иргэнд албан бичгээр өгнө.

2.10 "Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх өвчний жагсаалт"-д ороогүй өвчин, эмгэгтэй иргэнд гадаад эмчилгээний зардал олгох асуудлаар эрх бүхий албан тушаалтан шийдвэр гаргах, зөвлөлийн бүрэлдэхүүнд үүрэг өгөхийг хориглоно.

Гурав. Гадаад улсад эмчлүүлэх зардал

3.1. Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх иргэнд санхүүгийн дэмжлэгийг тухайн өвчнөөр нэг удаа олгоно.

3.2. Эмчилгээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэхдээ тухайн иргэнийг эмчилж эрүүлжүүлэхэд зарцуулагдсан зардлын баримт, материалыг үндэслэнэ.

3.3. Иргэний гадаад улсад очиж эмчилгээнд зарцуулсан нийт зардлын 5 хувийг үндэсний мөнгөн тэмдэгтээр бодож олгох ба тухайн үеийн Монгол банкны ханшаар тооцно.

3.4. Гадаад улсад эмчлүүлсэн иргэний тээвэр байр, хоол, түүнчлэн асран хамгаалагчаар явсан хүнд зардал олгохгүй.

Дөрөв. Хүлээлгэх хариуцлага

4.1. Холбогдох хууль, тогтоомж, энэ журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн албан тушаалтанд дараах хариуцлагыг ногдуулна.

4.1.1. Энэ журмын 2 дахь хэсгийн 2.1, 2.2, 2.3, 2.10-т заасан хэм хэмжээг зөрчин хувийн ашиг сонирхолд автан иргэдээс ирүүлсэн санал, хүсэлтийг эс шийдвэрлэсэн, 2.3-т заасан баримт бичиг нь бүрдээгүй иргэний асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж гадаад эмчилгээний зардал олгохыг завдсан бол сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

4.1.2. Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, энэ журмаар тогтоосон хэм хэмжээг илт хууль бусаар зөрчсөний улмаас байгууллага, иргэнд хохирол учруулсан гэм буруу нь эрүүгийн гэмт хэргийн шинжтэй бол уг албан тушаалтныг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулна.

18

Эрүүл мэндийн сайдын
2013 оны 08 дугаар сарын 29-ны
өдрийн 313 дүгээр тушаалын
4 дүгээр хавсралт

ГАДААД УЛСАД ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГААР ЭМЧЛҮҮЛЭХ ИРГЭДЭД ЭМНЭЛГИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь “Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх өвчний жагсаалт”-д орсон өвчин, эмгэгтэй иргэний асуудлыг хэлэлцэн төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн эмч нарын комиссын дүгнэлт (цаашид эмнэлгийн дүгнэлт гэх) гаргахад оршино.

“Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх өвчний жагсаалт”-д орсон өвчин, эмгэгтэй иргэний асуудлыг хэлэлцэж эмнэлгийн дүгнэлт гаргах бүрэлдэхүүн нь Эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсгийн 28.4.1, 28.4.3, 28.4.7 дахь заалтад тусгагдсан үүргийг баримтлан ажиллана.

1.2. Эмнэлгийн дүгнэлт гаргах комисс нь ажлын ур чадвар сайтай, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нараас бүрдсэн байна.

1.4. Эмнэлгийн дүгнэлт гаргах комиссын ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Комиссын хурал нь комиссын бүрэлдэхүүний 90 хувиас дээш ирцийг бүрдүүлсэн тохиолдолд эмнэлгийн эмч нарын зөвлөлгөөний дүгнэлтийг хүчинтэйд тооцно.

Хоёр. Эмнэлгийн эмч нарын комиссын дүгнэлт гаргах журам

2.1. Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.10, 15.1.12-т заасан эмнэлгийн эмч нарын комисс нь гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх иргэдэд эмнэлгийн дүгнэлт гаргана.

2.3. Эмнэлгийн дүгнэлт гаргах комиссын бүрэлдэхүүнийг тухайн байгууллагын дарга, захирлын тушаалаар баталгаажуулна.


2.4. Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх иргэнд эмнэлгийн дүгнэлтийг гаргахдаа нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийн бичлэг, онош, түүнийг баталгаажуулсан лабораторийн шинжилгээний болон дүрс оношлогооны хариуг үндэслэн тал бүрээс нь хэлэлцэн шийдвэрлэнэ.

2.5. Эмч нарын комисс нь хуралдааны тэмдэглэл хөтөлж, гарсан шийдвэрийг баталгаажуулна. Хуралдааны тэмдэглэлийн хуулбарыг Эрүүл мэндийн сайдын дэргэдэх гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлаар санал гаргах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлд хүргүүлнэ.

2.6. Эмнэлгийн дүгнэлтийн маягыг бүрэн бөглөж, эмч нарын комиссын зөвлөлгөөнөөр тогтоосон өвчний заалтыг тодорхой тусгасан шийдвэрийн маягт дээр зөвлөлгөөнд орсон эмч нар гарын үсгээ зурж баталгаажуулна.

2.7. Иргэн өөрийн хүсэлтээр гадаад улсад эмчлүүлэхээр гаргасан хүсэлт энэ журамд хамаарагдахгүй.

Эрүүл мэндийн сайдын
2013 оны 08 дугаар сарын 29-ны
өдрийн 313 дүгээр тушаалын
5 дугаар хавсралт



ГАДААД УЛСАД ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГААР ЭМЧЛҮҮЛЭХ
ИРГЭДЭД ЭМНЭЛГИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ МАЯГТ

Эмнэлгийн байгууллагын нэр

Өвчтөний овог _____ Эцэг эхийн нэр: _____

Нэр: _____

Төрсөн он ____ сар ____ өдөр: _____

Нас _____

Хүйс _____

Регистрийн дугаар _____

Мэргэжил/ _____

Ажлын газар/ сургууль _____

Хаяг _____

Утас _____

Эрүүл мэндийн даатгалын дэвтрийн дугаар _____

БОДИТ ҮЗЛЭГ:

Өндөр _____ Жин _____


Цусны даралт _____ Судасны цохилт _____

Одоогийн өвчний түүх

.....
.....
.....
.....

Шинжилгээнүүд

.....
.....
.....



Дүрс оношлогооны шинжилгээ

.....
.....
.....

Эмнэл зүйн онош

.....
.....
.....
.....

Комиссын шийдвэр (жагсаалтад байгаа өвчний онош, эмчилгээний заалтыг бичнэ.)

.....
.....
.....
.....

Тамга:

Комиссын дарга

..... /
гарын үсэг

нэр /

Комиссын гишүүд

1..... /
гарын үсэг

нэр /

2..... /
гарын үсэг

нэр /

3..... /
гарын үсэг

нэр /

Эмчлэгч эмч

..... /
гарын үсэг

нэр /